

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 7 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР
/ДАВАА ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-9
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-12
	1.Батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга танилцуулах	10-12
	2.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-28
	3.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	29-53
	4.Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	53-62
	5.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос 2020.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	62-66

Хураангуй тэмдэглэл

Гурав.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний төвийн Ажлын албаны дарга С.Тэнгис нар цахимаар тус тус оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн

хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт нар “Их хуралдай” танхимаас тус тус танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Н.Учрал, Г.Амартүвшин, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Ш.Адьяа, Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Их хуралдай” танхимаас, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар цахимаар тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн “Их хуралдай” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал цахимаар тус тус үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 27

Бүгд: 63

57.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Алсын хараа-2050, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын хууль, тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдээр, хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харьцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй, хувь хүний нууцтай байх, үүнийг хуулиар тогтоон хамгаалахаар заасны дагуу Монгол Улсын Их Хурал 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Хувь хүний нууцын тухай хуулийг баталж мөн оныхоо 7 сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Энэ хууль нь 3 бүлэг, 9 зүйлээс бүрдэх бөгөөд тус хуулиар хувь хүний нууцыг тодорхойлж, захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүл, хуулиар тогтоосон бусад нууцыг хувь хүний нууцад хамааруулахаар тогтоож, хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох.

Энэ хуулиар хамгаалсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхийн талаар зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулсан хэдий ч нийгмийн харилцаа тасралтгүй хөгжиж байгаа, технологийн хөгжлийг дэмжсэн энэ цаг үед нийгэмд үүсээд байгаа зарим төрлийн харилцааг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулахад бэрхшээлтэй нөхцөл, байдлууд үүссээр байгааг дурдах нь зүйтэй.

Жишээ дурдвал Хувь хүний нууцын тухай хуулиар хувь хүний нууцыг хязгаарлагдмал хүрээнд тогтоож, хувь хүнийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хэрхэх талаар тусгаагүй, хувь хүн нууцаа өөрөө хамгаалахаар заасан нь хувь хүний мэдээллийг хариуцаж байгаа этгээд үүрэг хүлээж байгаа олон улсын жишиг зохицуулалттай нийцээгүй. Мөн хуулиар хувь хүний нууцыг задруулснаар тухайн хүнд илтэд хохирол учруулж болзошгүй гэх хэт өндөр стандартыг тогтоож, хувь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд түүнийг хамгаалах боломжгүй боломжгүйд хүргэх, хүрэх зэргийг дурдаж болохоор байна.

Хувь хүний нууцын тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзэн Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь нийт 8 бүлэг, 32 зүйлтэй хуулийн төсөлд зарчмын

шинжтэй дараах асуудлыг тусгасан.

Үүнд нэгдүгээрт, хуулийн төсөлд нэр томьёоны тодорхойлолт оруулж, хувь хүний мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл биометрик, генетикийн эрүүл мэндийн мэдээлэл зэрэг юуг хамруулах, эдгээр мэдээллийн эзэн хэн болох мэдээллийг цуглуулах, нарийн боловсруулах, ашиглах ойлголтыг нарийвчлан бусад улс орны жишигт тулгуурлан нарийвчлан тодорхойллоо.

Хоёр. Хувь хүний мэдээлэл цуглуулахад мэдээллийн эзнээс зөвшөөрөл авдаг байх, эс үгүй бол хуульд заасан үндэслэлээр хувь хүний мэдээлэл цуглуулж, боловсруулах, ашиглах тохиолдлуудыг тогтоож, хүний эрүүл мэнд, хөрөнгө, захидал харилцаа, генетик, биометрик, цахим гарын үсэг, бэлгийн чиг хандлага, бэлгийн харилцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамааруулахаар тусгалаа.

Гурав. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад мэдээллийн эзний эдэлж болох эрх, хүлээх үүргийг тогтоож тухайн эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ хамгаалуулах талаар оруулж өгсөн.

Дөрөв. Мэдээлэл хариуцагч буюу мэдээллийн эзний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээдийн мэдээллийн эзний өмнөх хүлээх үүргийн талаар тусгасан. Мэдээлэл хариуцагч болон түүний үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн авч байгаа мэдээлэл боловсруулагч хүний мэдээлэл, хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах талаар аюулгүй байдлын талаар арга хэмжээ авах, мэдээллийн эзэн нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой илэрсэн зөрчлийг мэдэгдэх талаар оруулсан.

Тав. Хувь хүний мэдээлэл, хамгаалах эрх бүхий байгууллагын тогтоож, Хүний эрхийн Үндэсний Комисс энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллага энэ хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан.

Зургаа. Дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийн төхөөрөмжийг байршуулах тохиолдолд дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийн систем, тавигдах шаардлага, хориглох, хяналт тавих зохицуулалтыг тусгалаа.

Тухайлбал ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө, караоке, зочид буудлын өрөө, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, хэвтүүлэн эмчлэх өрөө зэрэг хувь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулахыг хориглохоор заасан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хувь хүний нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон хуулийн нэршлийг өөрчилж байгаатай уялдуулан холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулсан болно.

Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хуулийн төслийн үзэл баримтлалын хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж, дэмжин шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн Байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хүний хувийн мэдээлэл цуглуулах, бүртгэх, хадгалах, дамжуулах, ашиглах, өөрчлөх, устгах зэрэг мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаа явуулахад мэдээллийн эзэн болон хүний хувийн мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээд хоорондын эрх зүйн харилцааг тусгайлан зохицуулаагүй, эрх олгосон, зөвшөөрсөн, хориглосон үйлдлийг нарийвчлан зохицуулах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хууль санаачлагч аж ахуйн нэгж, байгууллагууд хувь хүнийг таньж баталгаажуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөл болон хувь хүний бусад мэдээлэл цуглуулахдаа анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглах, түүнчлэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж ашиглан хүний хувийн мэдээлэл цуглуулах, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх мэдээллийг олон нийтэд зөвшөөрөлгүйгээр ил болгох, бусдад дамжуулах зэрэг үйлдлийг бууруулахад чиглэсэн зохицуулалтуудыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар аж ахуйн нэгж, байгууллагууд зөвхөн өөрт шаардлагатай мэдээлэл цуглуулж байгаа эсэхийг хэрхэн хянах, хүний хувийн мэдээллийг цуглуулж, бүртгэж, хадгалж байгаа этгээд мэдээллийг задруулсан тохиолдолд хүлээх хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд халдаж, үүрэн холбооны харилцааг прокурорын зөвшөөрөлгүйгээр тагнасан, чагнасан тохиолдол байгаа эсэх, түүнчлэн коронавируст цар тахлын үед гар утсаар дамжуулан иргэний хөдөлгөөнийг хянаж байгаа бөгөөд тухайн мэдээлэл хаана хадгалагдаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир сонгуульд нэр дэвшигчдийн нэр төрд халдах асуудлыг зохицуулах, үүрэн холбооны оператор' компаниудын хүний хувийн нууцыг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлдэг арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг мэдээлэл ашиглах гэдэг нэр томъёог хэрхэн ойлгох, цуглуулж болохгүй мэдээллийг хуульчлах, түүнчлэн хууль бусаар мэдээлэл олж авсан этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төслийг Улсын ИхХуралд өргөн мэдүүлж, хуулийн төсөлтэй хамтад нь хэлэлцэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн хүний хувийн мэдээллийг хамгаалах чиглэлээр хэрхэн ажиллах талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн хууль хяналтын байгууллага болон хувь хүний зөвшөөрлийн үндсэн дээр хүний хувийн мэдээллийг авч ашигладаг байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал төрийн байгууллагууд цахим шилжилт хийх нэрийн доор мэдээлэл, технологийн төвүүд байгуулж, хүний нөөц, хүнд суртлыг нэмэгдүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хүний хувийн мэдээллийг задруулсан этгээдэд хүлээлгэх ял, шийтгэлийн бодлогыг чангаруулах, түүнчлэн Улсын Их Хурал хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудалд онцгой анхаарах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хувь хүн нууцтай байх, хүний хувийн нууцыг хамгаалж, хүндэтгэдэг байх соёлыг хэвшүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар мэдээлэл хариуцаж, хадгалж байгаа байгууллагын мэдээлэл устгах явцыг хялбаршуулах, иргэнд хүний хувийн мэдээллийг хамгаалах мэдлэгийг олгож, хандлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай талаар санал хэлсэн болно.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.2 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд цахимаар оролцож байгаа түрүүчийн хуультай мөн нэг адил. Түрүүн танилцуулсан. Протоколд тусгасан байгаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Хүрэлбаатарын Булгантуяа, Хассуурийн Ганхуяг гишүүнээр тасаллаа. Цахимаар 2 гишүүнээр тасаллаа. Нийт 10 гишүүн асуулт асууна.

Эхлээд эрхэм гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг.

Ё.Баатарбилэг: Хууль санаачлагчаас ганц нэг зүйл асууя. Тэгэхээр энэ хувь хүний мэдээллийн нууцыг хадгалахтай холбоотой эрх зүйн харилцааг зохицуулах томоохон хууль орж ирж байна гэж ойлгож байна. Сүүлийн үед олон нийтийн сүлжээ нэлээн мундаг хөгжчихсөн. Бас иргэд олон нийтийн дунд энэ олон нийтийн сүлжээний мэдээллүүд их хүчтэй нөлөө үзүүлдэг. Ийм л болчихлоо л доо. Янз бүрийн мэдээллүүд явах юм. Тэгж байтал энэ тэр мэдээллүүд, ялангуяа хувь хүнтэй холбоотой мэдээллүүд нь одоо төрийн байгууллагуудын эрхлэх асуудлын хүрээний тухайн хувь хүний нууцтай холбоотой мэдээллүүд л гараад яваад байж харагдаж байгаа байхгүй юу.

Хаанаасаа тэр мэдээллүүдийг авдаг юм. Энэ чинь одоо амьдрал баян юм. Янз бүрийн зорилгоор одоо хувь хүний мэдээллүүдийг задруулдаг юмнууд харагдаж л байна л даа. Одоо жишээлэхэд аж ахуйн нэгж, байгууллагууд тодорхой тендер сонгон шалгаруулалтуудад орохдоо бие биеийгээ намнах зорилгоор гэдэг юм уу, одоо зах зээлийн зарчмаараа явдаг чөлөөт өрсөлдөөний зарчмаар явдаг ийм тодорхой төрийн ажил үйл ажиллагаанд одоо өрсөлдөгчийгөө, одоо нэр хүндийг унагах зорилгоор ч гэдэг юм уу. Ингээд янз бүрийн зорилгоор ийм хувь хүний мэдээллүүдийг ингээд гаргаад явж байдаг. Тэр мэдээллүүд хаанаас гардаг

вэ гэхээр энэ төрийн байгууллагуудаас яг тэрийг хариуцдаг байгууллагуудаас л мэдээллүүд гараад байна гэдэг ийм хардлагууд байгаад байдаг юм л даа.

Мэдээж тодорхой мэдээллүүд, хувь хүнтэй холбоотой мэдээлэл авах эрх бүхий субъектүүд бол мэдээллээ аваад явна. Тэгж байтал тэр мэдээллүүдийг авах эрх бүхий субъект биш эх сурвалжуудаас энэ мэдээллүүд гараад байдаг л одоо тэр нь бас нийгэмд одоо тодорхой хувь хүмүүсийн ахуй амьдралд нэлээн сөргөөр нөлөөлдөг. Нэлээн хохироодог, ийм юмнууд гараад.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг нэмэлт 1 минут.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр энэ сүүлийн үед Нямбаатар сайдаас нэг зүйл асууя.

Энэ хуулиар одоо сүүлийн үед янз бүрийн аппликэйшнууд гарч ирж байна. Ялангуяа арилжааны зориулалттай тэр аппликэйшнийг бөглөхийн тулд хувь хүний янз бүрийн мэдээллүүдийг авдаг болж байна. Биометр одоо гар, хурууны хээнээс өгсүүлээд нүүр таних программ гэдэг юм уу. Тэгээд л янз бүрийн мэдээллүүд. Тодорхой нэр бүхий одоо олон том хүнсний дэлгүүрийн сүлжээ, хөнгөлөлтийн карт өгөхдөө хурууны хээ маш нарийн мэдээллүүд энэ тэр авч байна шүү дээ. Энэ болж байгаа юу, үгүй юу. Одоо нэрийг нь хэлээд яах вэ бас бизнесийнх нь нэр хүндийн асуудал. Өөрсдөө мэдэж байгаа. Манай олон үйлчлүүлэгч нар тэгж авдаг байх. Тэгэхээр энэ болж байна уу, үгүй юу. Тэгэхээр иймэрхүү юмнууд энэ хуулийн хүрээнд зохицуулагдах уу, үгүй юу гэдэг ийм нэг зүйл асуугаадахъя.

Г.Занданшатар: Хууль зүй, дотоод хэргийн сайд, эрхэм гишүүн Хишгээгийн Нямбаатар хариулна.

Х.Нямбаатар: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн одоо хамгийн гол том зорьж байгаа зүйл бол хувь хүний мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл, биометрик, генетикийн эрүүл мэндийн мэдээлэл зэргийг хэрхэн яаж хамгаалах вэ гэдэг ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Энэ хууль хэрвээ батлагдвал томоохон одоо сүлжээ дэлгүүрүүдэд хөнгөлөлтийн карт байдлаар хүний биометрикүүдийг цуглуулж байгаа энэ бүх мэдээллүүдийг хууль хэрэгжүүлэх хүрээнд төрийн тусгай байгууллагууд очиж одоо авч устгах энэ биометрик мэдээлэл зөвхөн төрд хадгалагдах байдлаар зохицуулах гэж байгаа юм. Бид нар биометрикийг цаашид ер нь бол их өргөн хүрээтэй ойлгох ёстой юм байна лээ.

Бид нар энэ хуулийг боловсруулж байхад л бас тийм зүйл ажиглагдсан. Жишээлбэл хүний алхаа, явдал хүний нүдний одоо энэ хараа торлог, нүүрний ерөнхий хэв, чихний омог гээд их олон зүйлүүдээс гадна сүүлийн үед манай урд хөршид энэ хүний судсаар гүйж байгаа цусны хурдац нь өөрөө дахин давтагдашгүй биометрик шинжийг агуулдаг гэж үздэг юм байна лээ. Тэгэхээр цаашид ерөөсөө энэ биометрик мэдээллийг төр, хувийн хэвшлийн тийм шаардлагагүй тохиолдолд ерөөсөө авахааргүй, зөвхөн төрд хадгалагдахаар болж байгаа юм. Биометрик дээр түшиглэсэн бид нар бас нөгөө Монгол Улсын иргэний 12 оронтой дугаараар энэ хүнтэй холбоотой бүх мэдээлэл төрд нэг ийм дугаар дээр хадгалагдана. Нийгмийн даатгал, татвар, одоо оршин суугаа байдал, боловсролын байдал, бүх зүйл энэ төрд өөрөө хадгалагдана. Энийг нь төр хамгаалах үүрэгтэй. Төр өөрөөс нь энэ мэдээллийг дахин дахин шаардах ёсгүй гэдгийг энэ Нийтийн мэдээллийн тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулиар бас давхар зохицуулж өгөхийг зорьж байгаа.

Тэгэхээр дэлгүүрүүдэд хадгалагдаж байгаа энэ биометрикүүд бол цаашид одоо үгүй болно. Энэ цаашаа урхагтай. Гэмт хэргийн газар энэ хүний биометрик мэдээллийг хуулбарлаад тавивал бас асуудал үүснэ.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Ням-Осорын Учрал асуулт асууна.

Н.Учрал: Нэгдсэн Үндэсний Байгууллагын тогтвортой хөгжлийн зорилт 2030 он хүртэлх баримт бичиг бол байгаа. Түүний бараг 90 хувь нь одоо бол мэдээллийн технологиос шууд хамааралтай болсон. Тэгэхээр энэ хамааралтай байгаа байдал нь өөрөө иргэд юуг шаардаж байгаа вэ гэхээр мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний мэдээллийг хэрхэн хамгаалах, өгөгдлийг нь хоорондоо хэрхэн солилцох вэ гэдэг зохицуулалтуудыг улс орнууд бол өөр өөрсдөө хийгээд явж байгаа. Тэгэхээр Европын холбоо бол өөрсдөө бас одоо конвенцтой, тэгээд тэр конвенцод нэгдэн орсон орнууд бол энэ нөхцөлүүдээ тохироод явж байгаа.

Тэгэхээр манай улсад бол энэ шинэ тутам бас хууль бол биш. Өмнөх хуулиар одоо иргэн хүн өөрийнхөө мэдээллийг хамгаалдаг байсан бол энэ хуулийн гол онцлог бол төр л одоо хэрхэн мэдээллийг хамгаалах вэ, хувь хүний нууцыг хамгаалах вэ гэдэг зохицуулалтууд тусгасан гэж ойлгож байгаа.

Нэг асуулт байна. Энэ Ковидын хууль гэдэг нэг үндсэн хууль шиг хууль байна. Энэ хууль чинь энэ хуулийг ер нь хэрэгжүүлүүлэх юм уу? Одоо Нийслэлийн Засаг даргын захирамж гаргаад иргэний үнэмлэхийн QR кодоо уншуулаа гээд байгууллага болгоны гадаа код уншуулаад байж байгаа шүү дээ. Тэр кодыг нь QR toot.mn гэдэг сайтыг чинь ажиллуулж байгаа байгууллага чинь хувийн байгууллага. Ингээд эхлэхээр гуравдагч этгээдэд иргэдийн мэдээлэл очоод байгаа байхгүй юу. Тэгээд Ковидын хуультай учраас гээд энэ хуулийг баталдаг. Тэгээд нэг Ковидын хууль чинь дээр гарчхаад ингээд бас үргэлжлүүлээд байх юм уу? E.barimt энэ иргэний үнэмлэхний QR, энэ мэдээллүүдээ иргэд ер нь хэрхэн хамгаалах юм бэ гэдэг асуулт бол байна.

Мөн энэ аппликэйшнүүдийг хэрэглэхэд бол нөгөө terms and condition гээд маш одоо урт заавар байдаг. Үүнтэй адилхан энэ хуульд яг энэ эрх үүргийг маш тодорхой бий болгож, иргэд yes гээд кноп дарахдаа яагаад дарж байгаа вэ гэдэг талаараа ойлголттой болгох ёстой учраас хуулиар нь энийг нээж өгөөд журамлаад зохицуулах хэрэгтэй юм байгаа юм.

Тэгэхээр энийг бол ажлын хэсэг дээр нэн одоо яаралтай бас ажиллаж нэлээн одоо олон талаас анхаарах ёстой байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Би Учрал гишүүний асуултад хариулъя. Сүүлийнхээс нь би эхлээд хариулъя. Ер нь бол энэ хуулийн дөрвөн багц хууль дээр нэг ажлын хэсэг гаргаж өгөөч гээд би Их Хурлын даргад хүсэлтээ тавиад ажлын хэсгийн бүтэц бүрэлдэхүүнд Байнгын хороодын төлөөллийг жигд хангаад оруулбал яасан юм бэ гээд саналаа хэлчихсэн байгаа. Их Хурлын дарга дээр энэ бас тогтоолын төслөө хүргүүлчихсэн байгаа. Энэ ажлын хэсгийг одоо яг ажил үүргийн хуваарийн хувьд бол танай Байнгын хороо, ялангуяа та өөрөө Байнгын хорооны даргын хувьд ахалж ажиллах болов уу? Энэ дээрээ та бүхэн маань бас маш тодорхой технологийн энэ боломж нөөцүүдийг бий болгох тал дээр ажиллах байх гэж бодож байна.

Ер нь бид нар цаашдаа энэ төрийн байгууллагад хандаж байгаа албан хүсэлтүүд зөвшөөрөл хүсэж байгаа юман дээр аппликэйшн форум бөглүүлдэг, тэгээд энэ дээр нь үндэслэж хиймэл оюун ухаан шийдвэрийг гаргадаг. Ийм байдлаар асуудалд хандаж явахгүй бол хүний оролцоот байдлыг л аль болох хумья гэж байгаа. Энэ дөрвөн хууль. Ингэснээрээ нөгөө авлигын индексээ бид нар нэлээн урагшаа буулгаж чадна гэдэг ийм итгэлтэйгээр оруулж ирж байгаа юм.

Хоёр дахь асуултад хариулъя энэ хууль мэдээж хэрэг батлагдаж гарч ирэхээрээ хууль хоорондын зөрчлийг бид нар бас арилгах ёстой. Ер нь бол Засгийн газраас барьж байгаа чиг бол энэ Ковидын хуулийг нь 12 сарын 31-нээр нь үйлчлэлийг зогсооё гэдэг асуудлыг өнөөдөр Ерөнхий сайд ярьсан.

Ер нь цаашдаа бид нар энэ Ковидын талаарх барих бас хандлага юун дээр бас өөрчлөлт гаргах ёстой. Сингапур энэ тэр бол энэ пандемик биш эндемик боллоо. Энэ чиглэл рүүгээ зохицож ажиллая гэдэг ийм шийдвэрүүдийг Сингапур төдийгүй ер нь дэлхийн олон улс орнуудад ийм одоо шийдвэрүүдээ гаргаад эхэлж байна. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор энэ Ковидын хүнд үед аль болох ард иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах энэ чиглэлийнхээ эрчимтэй ажлуудыг хамгаалаад халдвар хамгааллын дүрмээ бариад бүх одоо салбар чиглэлүүд маань нээгдэж энэнтэйгээ зохицож ажиллах энэ чиглэл рүү л бид нар бас явахаар зорьж байгаа.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин.

Г.Амартүвшин: Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

Ер нь бол манайд байхгүй хууль, тогтоомж гэж бага ойлгож байгаа шүү дээ Нямбаатар сайд аа. Одоо тэгээд энэ хуулийг ингээд уншихад ер нь бол мэдээллийн эзэн буюу хувь хүн зөвшөөрлөө өгвөл мэдээллийг нь цуглуулж болно, хадгалж болно, цаашаа дамжуулж болох л юм байна шүү дээ. Өөрөөр хэлбэл эзэн л зөвшөөрлөө өгчих юм бол цаашаа ер нь хяналтгүй болох тийм эрсдэл байгаа юм биш үү.

Ер нь ингээд бид нар чинь банкн дээр юм уу, аль нэг одоо аж ахуйн нэгжийн үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн авахдаа гэрээ зурдаг. Тэр гэрээнийх нь нэг заалтад нь таны мэдээллийг бид нар одоо цуглуулна цаашаа ашиглана. Ингээд үндсэндээ тэр заалт орчихдог. Тэрийг нь бид нар одоо 99 хувь нь ойлгохгүй, уншихгүй, тоохгүйгээр гарын үсгээ зурчихдаг. Тэр нь л ингээд зөвшөөрөл болоод явчих юм байна л даа. Тэгэхлээр энэ тал дээр бас ямар тохиолдолд мэдээллийг нь цуглуулахад зөвшөөрөл аваад, дамжуулахад нь бас нэг зөвшөөрөл аваад яаж боловсруулж ашиглахыг нь бас нэг зөвшөөрөл авах тийм боломж бололцоо байна уу? Тэгж тусгасан уу, үгүй юу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт мэдээлэл маш их алдагдаж байгаа. Одоо жишээлбэл сошиалаар хүний, одоо хувь хүний гар утаснаас авхуулаад л оршин суух хаяг, бүр регистрийн дугаар ингээд гэх мэтчилэн мэдээлэл бол ер нь чөлөөтэй олдох, олдохын хувьд олдог л юм байна лээ. Тэгэхлээр энэ энэ асуудлыг энэ хуулиараа ер нь хааж байгаа юу? Хаахгүй байгаа юу? Энэ мэдээллийг төрийн байгууллага юм уу аж ахуйн нэгжүүд задруулсан юм уу? Одоо зөвшөөрөлгүй мэдээлсэн байвал ямар санкц хүлээхээр байгаа вэ?

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн төсөл бол анхдагч хуулийн төсөл биш юм. Энэ шинэчилсэн найруулга. Өмнө нь 1995 онд Хувь хүний нууцын тухай хууль гэж баталсан. Түрүүн Учрал гишүүн энэ хуулийн ерөнхий концепц агуулгыг хэллээ. Тухайн үеийн хуулиар бол ер нь хувь хүн өөрийнхөө мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах энэ үүрэг нь тухайн хувь хүндээ ноогдож байсан. Одоо сүүлийн үеийн мэдээллийн технологийн энэ хурдацтай цаг үе, нийгмийн харилцаанд гарч ирж байгаа олон дэвшлүүдтэй зэрэгцээд бид ер нь төр бас энэ хувь хүний нууцыг хамгаалахад бас оролцох үүрэгтэй юм байна. Төр хувь хүний нууцыг хамгаалахад бас үүрэг хүлээе ээ, зохицуулалт хийе гэдэг ийм агуулгаар энэ хууль бичигдсэн.

Хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад эзний эдэлж болох эрх үүргийг тогтоож, тухайн эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ яаж хамгаалах талаар энэ хуулийн төслөөр бас зохицуулахыг зорьж байгаа.

Мэдээлэл хариуцагч буюу мэдээллийн эзний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээдийн мэдээллийн эзний өмнө хүлээх үүргийг бас тусгасан. Ер нь бид нар энэ дээр олон талаас нь л харах юм байна лээ. Энэ нэг талаасаа банкны салбар ч гэдэг юм уу бусад иргэдтэй шууд харилцаанд ордог байгууллагууд ийм үүрэг хүлээж байхад зэрэгцүүлээд энэ бас хэвлэл мэдээллийн салбартай холбоотой зохицуулалтыг ч бас хийхийг энэ хуулийн төсөл боловсруулж байх явцад зарим ажлын хэсэгт орсон хүмүүс хэлж байсан.

Тухайлах юм бол гаднын улс орнуудад Амартүвшин гишүүний талаарх мэдээллийг нийтэлж, янз бүрийн скандал үүссэн тохиолдолд нийтлэхдээ өмнө нь өөрөөс нь юм уу, эсвэл өөрийнх нь хэвлэлийн төлөөлөгчөөс энэ талаар бас тодруулга авч ингээд хоёр байр суурийг дандаа цуг нийтэлдэг ийм зохицуулалт дэлхийн улс орнуудад нэлээн түгээмэл хөгжсөн юм байна лээ.

Манайд бол ийм зохицуулалтгүйгээс болоод энэ хооронд хуулийн зөрчил, хүний эрхийн зөрчлүүд энэ тэр гардаг. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ ажлын хэсэг дээр бас энийг давхар хамтдаа ярих ёстой. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа энэ хувь хүний мэдээллийг задруулсан бол хариуцлага.../минут дуусав/.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин тодруулж асууна.

Г.Амартүвшин: Тэгэхлээр Нямбаатар сайдын саяхан нэг хэлсэн тайлбар дээр бас биометрикийн мэдээлэл бол зөвхөн төрийн мэдэл төрийн одоо эзэмшилд байна гэж ойлгосон тэр бол зөв үү? Өөрөөр хэлбэл жишээлбэл бид нар чинь бас л энд тэндгүй хурууны хээгээ уншуулаад үйлчилгээгээ авч байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ мэдээлэл нь одоо хур, дан систем дээр бас тодорхой хэмжээгээр байршдаг. Тэгэхлээр энэ мэдээлэлд нь хандаж болох юм уу, аж ахуйн нэгжүүдэд.

Энэ мэдээллийг нь ашиглаж болох юм уу? Энэ тоон гарын үсэгтэй яаж энэ хууль чинь уялдаж байгаа юм?

Г.Занданшатар: Эрхэм гишүүн, сайд Хишгээгийн Нямбаатар асуултад хариулна.

Х.Нямбаатар: Энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа Цахим гарын үсгийн тухай хууль ярина.

Энэ дээр бас нэлээн дэлгэрэнгүй хэлье гэж бодож байна. Ер нь бол би өмнө хэлсэн үгээ л дахиж давтаж хэлье. Ерөөсөө хувь хүний биометрик мэдээлэл бол зөвхөн төрд л хадгалагдана. Хувь хүний тэр биометрик мэдээлэл дээр суурилсан

тэр хүний талаарх дундын мэдээллийн сан улсын бүртгэл дээр бүрдэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ 12 оронтой дугаар дээр үүсэж байгаа юм. Энэ хүн мэдээллээ авахын тулд биометрик төрийн эрх бүхий байгууллага дээр хурууны хээгээ уншуулаад мэдээллээ авч болдог эс үгүй бол цахим гарын үсгээрээ мэдээллээ авч болдог. Ийм байдлаар л төрд хадгалах мэдээлэлтэйгээ мэдээллийн эзэн эзэмшиж ашигладаг. Ийм байдлаар зохицуулалтыг оруулж ирж байгаа. Хувийн сектор дээр ямар нэгэн байдлаар банкны салбар ч юм уу үйлчилгээний бусад бүх салбар дээр биометрик мэдээлэл хадгалагдахгүй. Энэ хуулиар төр биометрик мэдээллийг чинь бид хадгалж хамгаалж өгье гэдэг бас давхар зохицуулалт орж ирж байгаа юм.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуулт асууна.

М.Оюунчимэг: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай энэ хуулийн төсөл орж ирж байгаад бол үнэхээр талархалтай хандаж байна. Энэ дээр бол бас ажлын хэсэгт орж ажиллая гэж бодож байна. Сая Нямбаатар сайд хэлж байна л даа. Жишээ нь, хэвлэл мэдээлэлтэй холбоотой хуулиуд ч гэсэн өөрчлөлт оруулах хэрэгтэй байгаа гээд байна. Уг нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, энэ Хэвлэл мэдээллийн тухай хууль дээр тухайн хүний тухай одоо ноцтой баримт ч юм уу аливаа нэг мэдээлэл цацах бол тэр хүнээс юм уу, хоёр талын байр суурийг заавал тэнцвэртэй хүргэх ёстой гэсэн сэтгүүл зүйн дүрэм байдаг юм. Уг нь энэ хууль дээрээ байдаг юм. Гэтэл манай одоо улс төрчид, ер нь энд тэнд олон нийт ч гэсэн олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн редакцтай байгууллага хоёрын ялгаа одоо бүр байхгүй болчихсон. Бараг хэвлэл мэдээллийн үүргийг нөгөө сошиал гүйцэтгээд байдаг. Энэ нь өөрөө өнөөдөр одоо хувь хүний нууцыг бүр байхгүй болгож байгаа, энд тэндгүй хамаагүй бичлэг хийж байгаа, гар хөлийн үсэг авдаг болчихсон гээд ийм замбараагүй юм байгаад байгаа юм.

Тиймээс Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Англи байна. Одоо энэ Оросын Холбооны Улс, Сингапур олон нийтийн сүлжээний зохицуулалтын хууль гарчихсан. Энэ хууль нь Хэвлэл мэдээллийн хуулийн эрх чөлөөтэйгөө ингээд зөрчилдөхгүйгээр ингээд явуулчихсан байгаад байгаа юм. Гэтэл манайд тийм зүйл байхгүй байгаад байгаа юм. Тэгээд Нямбаатар сайдаас асуух гэж байгаа юм. Бид өмнө нь бас олон нийтийн сүлжээний зохицуулалтын энэ хууль гарахгүй бол болохгүй байна гэдгийг тэр олон нийтийн сүлжээнд оролцогчид өөрсдөө хүртэл хүсээд байсан. Бид өнгөрсөн дөрвөн жил гаргах гэсэн боловч бас тэгээд одоо улс төрөөсөө болгоомжлоод гаргаж чадаагүй л дээ. Тэгэхээр хүний хувийн мэдээллийг хамгаалах энэ хууль тэр олон нийтийн сүлжээг зохицуулахтай юман дээр яаж энэ хоёр авцалдаж байгаа вэ? Би энийг асуух гээд байгаа юм.

Одоо Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. Энэ Хүний хувийн мэдээлэл авах тухай хууль хоёр маань яг энэ шүүх дээр очоод тухайн хүн нь маргаан дээр очингуутаа хоорондоо зөрчилдөөд, тухайн шүүгч өөрийнхөө үзэмжээр тайлбарладаг байх. Энэ юмыг л хааж өгөхгүй бол манай бүх хууль нэг нь нөгөөгөө үгүйсгэдэг, нэг нь нөгөөтэйгөө зөрчилддөг, тэгээд хэрэгжиж чаддаггүй, энэ дээр нь нөгөө хууль бус ажиллагаанууд явчихдаг ийм байдаг юм. Тэгээд энэ талаар эхлээд хариулт авч байгаад дараа нь.

Г.Занданшатар: Эхлээд эрхэм гишүүн, сайд Хишгээгийн Нямбаатар хариулъя. Дараа нь ажлын хэсэг, Баасандорж дарга тэр биометрик гэсэн талаар бэлдэж байгаарай. Энэ концепцоосоо арай жаахан өөр ойлголт яваад байна шүү. Энэ Амартүвшин гишүүний асуулт энэ тэртэй холбогдуулаад. Сая энэ Оюунчимэг гишүүний асуулт ч гэсэн. Ингээд Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Зүгээр Засгийн газар дээр нэг хуулийн төсөл бэлдсэн юм байгаа. Энэ нийгмийн сүлжээний зарим компаниудын төлөөлөгчид Монгол Улсад ирэхээрээ юу гэж хэлдэг вэ гэхээр танайд энэ харилцааг зохицуулсан хууль байхгүй ээ, хуулиа баталбал бид нар бас өөрсдийнхөө төлөөлөгчийн газрыг байгуулах боломжтой гээд. Нэлээн хэдэн жилийн өмнө Их Хурлын дарга Занданшатар дарга, Ерөнхий сайд, Оюун-Эрдэнэ сайд бид гурав Холбооны Бүгд Найрамдах Герман улсад яваад энэ Европын холбоо, тэр дундаа Холбооны Бүгд Найрамдах Герман улсад энэ сошиал харилцаагаа ямархуу байдлаар зохицуулж байгаа юм бэ? Тухайн хуулийг нь баталсан тэр парламентын гишүүдтэй бас бид нар уулзалт хийж туршлага судалж байсан юм. Тэгээд энэ хүрээндээ, ер нь Европын холбоонд энэ нийгмийн сүлжээний компаниудыг хүлээх үүрэг хариуцлагатай нь холбоотой. Энэ хуулийн төсөл дээр бид нар суурилсан хуулийн төслийг бэлдээд явж байгаа. Энэ дээр яг одоо тэр раск news гаргасан тохиолдолд нь раск news-ийг устгах үүргийг тэр тухайн нийгмийн сүлжээний компаниуд хариуцдаг ийм учиртай юм байна лээ. Тэгээд энэ чиглэл рүүгээ бид нар бас ажиллаж байгаа. Тэгээд энэ боловсруулалт хийгдээд олон нийтээс санал авсны дараа Засгийн газрын хуралдаанаар одоо хэлэлцүүлэх ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Баасандорж дарга гараа өргөж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам Баасандорж асуултад хариулъя.

Энэ хуулийн гол үзэл баримтлал нь бол ер нь мэдээллийн эзний эрх гэж яг юуг хэлэх юм. Мэдээлэл хариуцагч, ялангуяа гишүүд сая мэдээлэл хариуцагчийн талаар нэлээд хөндөж байна. Мэдээлэл хариуцагч гэдэг бол төрийн байгууллага, хувийн хэвшил бүх төрлийн хувийн хэвслүүд. Тэгээд иргэд энэ хуулийн үйлчлэлт л орж байгаа. Ялангуяа хувийн хэвшил бол төрийн байгууллагын мэдээж хууль тогтоомжинд хүлээсэн үүргээрээ бол тэр хариуцагчийн эрх үүргээ хүлээнэ.

Ялангуяа сүүлийн үед нам маш олон тохиолдлууд гардаг. Энэ хувийн хэвслүүд дээр хувь хүний мэдээлэл маш ихээр хуримтлагддаг. Гагцхүү тухайн эзний зөвшөөрөлтэйгөөр тухайн одоо хувийн хэвшил маань одоо жишээ нь эрүүл мэндийн байгууллага. Тухайн иргэний зөвшөөрөлтэйгөөр нэг эрүүл мэндийн байгууллага, нөгөө хувийн эрүүл мэндийн байгууллагадаа зөвхөн шилжүүлбэ. Зөвшөөрөлгүйгээр хэрвээ бусдад шилжүүлэх, олон нийтэд түгээх юм бол хариуцлага хүлээе гэдэг зүйл орж байгаа.

Өөрөөр хэлбэл энэ хуулийн үйлчил маань төрийн байгууллага, хувийн хэвшлийн аль алиных нь харилцааг зохицуулж байгаа мэдээлэл хариуцагчийнх нь хувьд.

Дээрээс нь гишүүдийн хөндөж байгаа нэг чухал асуудал бол энэ биометрик буюу гарын хурууны хээ болон генетик биометрик өгөгдлийн талаар нэлээн асууж байна. Энэ хуулийн 10 дугаар зүйл дээр ерөөсөө яг 10.1 дээр дөрвөн төрлийн байгууллагаар одоо энэ мэдээллийг цуглуулахыг бол хуульчилж өгсөн байгаа.

Нэгд бол улсын бүртгэлийн байгууллага иргэний улсын бүртгэл хөтлөх, сонгогчийн бүртгэл хянах зорилгоор л хүний хурууны хээг ашиглана шүү.

Хоёрт нь Гадаадын иргэний хурууны хээг хил хамгаалах байгууллага зөвхөн хариуцсан шүү. Мөн хуульд заасан эрх бүхий байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор биометрик болон генетик мэдээллийг ашиглана шүү.

Дөрөвт нь шүүхийн шинжилгээний байгууллага маань генетик мэдээллийн биометрик болон генетик мэдээллийг ашиглана шүү гэж хуульч ч өгсөн.

Бусад ямар ч нөхцөлд энэ гарын хурууны хээ болон генетик мэдээллийг ашиглахгүй гэж хуульчилж өгсөн байгаа юм. Өнөөдөр бол банкин дээр банк бус санхүү дээр одоо хувийн хүнсний дэлгүүр дээр гарын хурууны хийг бол дэндүү замбараагүй ашиглаж байгаа. Яг энэ асуудлыг л зохицуулах гэж тухайн иргэний өөрсдийнх нь зөвшөөрөлтэйгөөр. Одоо энэ мэдээллийг цуглуулдаг байя, хариуцдаг байя, бусдад түгээдэг байя. Харин тэр тухайн иргэний мэдээллийг бусдад түгээх юм бол тэр мэдэгдэх өгөгдөл нь тэр иргэндээ очдог байя. Ингэснээрээ тэр төрийн байгууллага маань ч хяналтаа тавина. Хувийн хэвшлүүд маань ч гэсэн үүрэг хариуцлага хүлээдэг юм.

Г.Занданшатар: Баасандорж дарга гүйцээж хариулах уу.

Нэмэлт нэг минут Баасандорж даргад.

Б.Баасандорж: Хэрвээ энэ хууль батлагдах юм бол одоо жишээлбэл бид нар энэ хуулийн төслийг боловсруулахад хэд хэдэн судалгаануудыг хийж үзсэн л дээ.

Ялангуяа энэ хувийн одоо хүнсний дэлгүүрүүд дээр гэхдээ тэр бол тухайн хувийн хэвшлийнх нь өөрсдийнх нь буруу биш. Тухайн иргэн маань өөрийнхөө зөвшөөрснөөр тэр гарын хурууны хээгээ хадгалуулдаг. Жишээ нь мембер шиф болох гэж тухайн байгууллагын иргэн болгох гэж. Мөн одоо зарим төрлийн одоо хувийн эмнэлгүүд дээр тухайн өөрийнхөө бүртгэлийг хийлгэх гэж өөрийнхөө эрүүл мэндийн үзлэгт орохын тулд тухайн хувийн хэвшлээс шаардсан бүх мэдээллийг өөрийнхөө зөвшөөрлөөр өгдөг.

Өөрөөр хэлбэл энэ иргэн, хувийн хэвшил хоёрын хоорондын аль аль тал хоёр тал хүлээн зөвшөөрснөөр цуглуулсан мэдээлэлд бол энэ мэдээллийг хүлээж авч болохгүй, энэ мэдээллийг өгч болохгүй шүү гэсэн зохицуулалт бол энэ хуулиар орохгүй. Иргэн өөрөө өөрийнхөө эмзэг мэдээллийг ялангуяа хүлээн зөвшөөрөөд тухайн байгууллагад хуримтлуулах юм бол энэ хуулийн зохицуулалт орно.

Гагцхүү тэр төрийн байгууллагаас хяналтыг тавьж байгаа. Жишээ нь тэр хуулийн байгууллагаас нь тэр үндэсний дата төвөөс, тагнуулын байгууллагаас энэ хүний хувийн эмзэг мэдээллийг хэрхэн яаж хамгаалах юм, системийн аюулгүй байдлыг нь хэрхэн яаж одоо аюулгүй байх юм гэдэг талаас нь төр бол бүх талын хяналтыг тавьж хамгаалж байгаа.

Иргэн өөрөө хүлээн зөвшөөрөөд.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн нэмэлт нэг минут.

М.Оюунчимэг: Сая Баасандорж даргын ярианаас маш сайн ойлголоо. Энэ хурууны хээг ёстой замбараагүй ашиглаж байгаа үнэнийг хэлэх манайд. Дэлгүүрүүд ашиглаж байна сүүлдээ саун фитнес хүртэл ашиглаж байна гээд хүмүүс яг гомдол мэдүүлээд байгаа учраас бид энийг ер нь маш богино хугацаанд ойрын үед энэ хуулиа намрын чуулганаараа хэлэлцэж батлаад ирэх оноос ер нь энийг болиулах асуудлыг бол шуурхай хийх хэрэгтэй гэж бодож байна. Тэгээд би Нямбаатар сайдыг нөгөө миний дахин дахин яриад байгаа нь хууль хэрэгждэг л байх ёстой. Тэрнээс хууль дутаагүй бид гаргаад л байдаг. Хэрэгжихдээ энэ явахгүй байгаа. Сая тэр Мэдээллийн ил тод байдал дээр ч гэсэн бүрэн хэрэгжих

боломжгүй гэдэг шиг энэ Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль гарангуут бас боломжгүй гэдэг юм явчихвий.

Яагаад гэвэл энэ дээр мэдээлэл ашиглах гэдэг нэр томъёог яаж ойлгох вэ? Тухайн хүний одоо өөрийн хувийн page дээрээ тавьсан гэр бүл, үр хүүхдийнх нь зургийг ашиглаад янз бүрийн юм гүтгэх ийм юмнууд бол бүр замбараагүй болчихсон шүү дээ. Тэгэхээр энэ хууль гарснаар энэ бүгд цэгцрэх үү. Одоо ингээд ажил яриад гишүүд ч юм уу одоо өөр хүмүүс юм яриад ингээд явж байхад бүр сайдынхаа өрөөнд бичлэг хийгээд, дараа нь бас энийг олон нийтийн сүлжээнд тавина шүү гэж сүрдүүлж байсан тохиолдол ч ингээд гарч байсан. Манайхан ярьдаг шүү дээ. Тийм юмнууд өмнөх жилүүдэд.

Тэгэхээр бид нар энэ нууцаар дүрс бичлэг, дуу-дүрс бичлэг хийж тавих хүнд мэдээлэлгүйгээр ингэж худал мэдээлэл хүний тэр гэр бүлийнхэн нь үр хүүхдийнх нь зургийг ашиглаж ингэх явдлууд энэ хууль гарснаар бүрэн цэгцлэгдэж зогсоно гэж ойлгож болох уу? Энэ дээр нэг хариулт авчихъя.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар хариулна.

Х.Нямбаатар: Ер нь бол одоо ч гэсэн Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар энэ хууль бусаар нууц, далд аргаар бичлэг хийх гэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг зураг авсан тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг. Ийм юу байгаа шүү дээ. Зохицуулалт байгаа. Тийм энийг бид нар бас цаашид илүү одоо хувь хүн өөрийнхөө энэ мэдээллийг хамгаалах, энэ чиглэл рүүгээ энэ зохицуулалтыг илүү боловсронгуй болгох зорилгоор л энэ хууль гарч ирж байгаа юм. Тэгээд энэ хуулийг дагаад Эрүүгийн хуульд бас дагаж өөрчлөлт орно. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт орно. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт орно. Энэ Хувь хүний нууцыг хамгаалахтай холбоотой одоо түүнд хяналт тавьж ажиллах байгууллагыг бас ийм тодорхой болгож байгаа. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс энэ хуулийн хэрэгжилтэд бас давхар хяналт тавьдаг. Ийм одоо зохицуулалт руу орж байгаа.

Ер нь сүүлийн жилүүдэд нэг тийм нууц далд аргаар бичсэн бичлэгийн ийм уралдаан сонгууль болгоноор болдог. Орцны камерын бичлэгийг гаргаж одоо кино хийдэг ийм одоо зүйлүүд гарч ирсэн. Энийг цаашид бид нар маш тодорхой болгож, хариуцлага хүлээлгэх, ял шийтгэлийн төрлийг нь чангатгах тухайн тэр камер болон бусад энэ дуу, дүрсний бичлэгийг хийж байгаа хүмүүст хүлээлгэдэг хариуцлагыг тодорхой болгох, тухайн тэр дуу дүрсний бичлэгийг хадгалж байгаа хүмүүсийн хүлээх үүрэг хариуцлагыг бас тодорхой болгох чиглэлээр энэ хууль маань өөрөө гарч байгаа гэдгийг бас Оюунчимэг гишүүнд нэмж хэлье.

Дашрамд нь сонирхуулаад нэмээд хэлэхэд ер нь тэр тухайн хүний талаарх мэдээллийг төрийн байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийг ч гэсэн авсан, үзсэн тохиолдол болгонд тухайн хувь хүн бүр дээр notification e.mail ирдэг энэ зохицуулалтыг бас энэ дөрвөн багц хуулиар хамтад нь шийдэж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Цэндийн Сандаг-Очир цахимаар асуулт асуунаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа.

Хувь хүний нууцын мэдээллийн тухай ярьж байна. Ер нь нууц, нууцтай юм гэж байгаа больсон доо. Нууц ер нь бүх л юмнуудыг, ер нь мэдээллийг хаанаас л

бол хаанаас авдаг болчихсон. Хана хүртэл чихтэй болсон гэж ярьдаг шүү дээ. Тэгээд энэ одоо сүүлийн үед технологи өндөр хөгжсөн хувь хүнийг одоо мөшгөж цагддаг, байршлыг илрүүлдэг. Мөн одоо чагнадаг, мөн одоо мессежийг нь уншдаг, яриаг нь сонсдог гээд ингээд ер нь авъя гэсэн мэдээлэл бүрээ л авдаг. Ийм л одоо нийгэмд бид нар амьдарч байна шүү дээ. Тэгэхээр энэ хуульд одоо хэрвээ ингэсэн тохиолдолд хувь хүний мэдээллүүдийг хувь хүнийг одоо хуулийн бус хувь хүмүүс өөрсдөө ашигтай мэдээлэл олж авахын тулд ингэсэн тохиолдолд ер нь энэ асуудлыг, хариуцлагын асуудлыг ер нь яаж энэ хуульд оруулж ирсэн бэ?

Тэр битгий хэл банкны мэдээллийг хувь хүний харилцах болон хадгаламжийн дансыг мэддэг. Иргэний бүртгэлээс одоо үл хөдлөх хөрөнгийн мэддэг. Ингээд ер нь хувь хүнтэй холбоотой бүхий л мэдээллээ авъя л гэвэл авахаар одоо ийм байгаа шүү дээ. Нууцын асуудал бол үнэхээр одоо холбогдох ажил хариуцсан улсуудын хувьд бол гаргачхаад байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр одоо ингэсэн тохиолдолд иргэний бүртгэлийн ажилтан, банкны ажилтнууд энэ одоо гүүрэн операторууд, хувь хүний мэдээллийг гаргасан тохиолдолд яах вэ. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргаад хүнийг цагдан одоо ингэсэн байвал яах вэ? Энэ тал дээр энэ хууль одоо хэрхэн одоо зохицуулагдаж байгаа вэ гэдгийг бас тодруулж асууя.

Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга цахимаар.

Б.Баасандорж: Хууль зүй, дотоод хэргийн Баасандорж гишүүний асуултад хариулъя. Саяын гишүүний хөндсөн асуудал бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиараа ч г зохицуулагдаж байгаа. Гэхдээ бид энэ өргөн мэдүүлсэн дөрвөн хуулиар өшөө илүү нарийвчилж зохицуулж өгч байгаа. Өөрөөр хэлбэл тухайн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлтэйгөөр эрх бүхий албан тушаалтан тухайн гэмт хэрэг, зөрчилд тодорхой үйл ажиллагаа явуулдаг. Тэгэхээр олж мэдсэн тэр мэдээллээ хуримтлуулсан мэдээллээ тухайн одоо өөрийнхөө ажил үүрэгтэйгээ үл хамаарах, одоо бусдад мэдээлэх, нийтэд мэдээлэх юм бол өөрөө хуулийн хариуцлагатай. Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулиар. Мөн улсын бүртгэлийн асуудлыг хөндлөө. Улсын бүртгэлийн бүртгэгч нар маань зөвхөн өөрийнхөө, одоо тэр бүртгэж байгаа бүртгэлийг л тухайн системдээ оруулах одоо бүртгэлийн үйл ажиллагаагаа хөтлөх одоо ийм хуультай журамтай байгаа. Мөн бусдад мэдээлэх юм бол мөн одоо Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээх үүрэгтэй юм.

Ялангуяа энэ нөгөө техник, технологи хөгжиж байгаатай холбоотойгоор бол өмнө нь бол бас янз бүрийн ийм байдал бол гарч байсан уу гэвэл би бол гишүүнтэй санал нэг байна. Улсын бүртгэлийн багц дөрвөн хууль батлагдсанаас хойш одоо ялангуяа бүртгэл дээр гардаг одоо мэдээлэл ил болдог зүйлүүд илүү бол одоо чанга болсон, сайжирсан гэж үзэж байгаа.

Гэхдээ энэ мэдээлэл ил болж байгаа асуудлууд бол ингээд янз бүрийн одоо судалгаа хийж үзэхэд янз бүрийн хүчин зүйлээс шалтгаалдаг юм байна лээ. Нэгд бол энэ төрд байгаа мэдээллийг маш олон байгууллагууд үзэж ашигладаг. Мөн дээрээс нь хувийн хэвшлүүд одоо бас ашигладаг. Энэ хүний хувийн мэдээллийг. Тэгэхээр яг энэ өөрийн тэр хувийн байгууллагын ашиглаж байгаа мэдээлэл, хувийн хэвшлийн ашиглаж байгаа мэдээлэл дээр яг энэ төрийн нэгдсэн хяналтын систем байдаггүйгээс болж энэ одоо үнэний хувийн мэдээлэл алдагдах эрсдэл бол

гардаг. Энийг л яг одоо манай өмнө нь сая хэлэлцэхийг дэмжсэн Нийтийн мэдээллийн тухай хууль, энэ Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль.

Дээрээс нь мөн одоо энэ Кибр аюулгүй байдлын тухай хууль одоо хэлэлцэгдсэн байгаа. Энэ хуулиудаар л одоо хамгаалъя гэдгээр яаж байгаа юм. Саяын мөн гишүүний хөндсөн асуудлын нэг нь бол яг тэр хүний хэрвээ хувийн мэдээлэл бусдад дамжуулагдах юм бол тэр иргэний одоо, таны ийм мэдээллийг, одоо ийм эрх бүхий албан тушаалтан үзлээ гэдэг одоо мэдэгдэх одоо тийм системийг бий болгож байгаа энэ хуулиар. Өөрөөр хэлбэл таны одоо үл хөдлөх бүртгэлийн мэдээллийг одоо Хууль зүй, дотоод хэргийн яамны Баасандорж гэдэг хүн үзлээ гэх юм бол тухайн иргэн гомдол гаргадаг боломжийг нь нээж өгсөн.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Ширнэнбандийн Адьшаа асуулт сууна.

Ш.Адьшаа: Энэ Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжих боломжгүй байна. Энэ Монгол Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд заасан Хүний эрх чөлөөг хамгаалах тухай үндсэн энэ үзэл баримтлалтайгаа зөрчилдсөн ийм хуулийн төслийг оруулж ирсэн гэж үзэж байна. Өнөөдөр иргэдийнхээ энэ эрх чөлөөг чагнах тагнах, хууль бусаар одоо бичлэг хийх энэ асуудал бол сүүлийн жилүүдэд хэрээс хэтэрсэн.

Энийг өнөөдөр Засгийн газар бүр хууль болгож оруулж ирж, иргэнийхээ Үндсэн хууль зөрчсөн ийм асуудлыг оруулж ирж байгаа нь бас үнэхээр харамсалтай байна.

Хоёр асуулт асууя. Одоогийн дагаж мөрдөж байгаа эрүүгийн болон бусад хууль тогтоомжоор бусдыг хууль бусаар чагнасан тагнасан. Түүнчлэн дүрс бичлэг хийсэн иргэн, албан тушаалтанд ямар одоо хариуцлага хүлээлгэсэн, хэчнээн одоо хэрэг зөрчил байгаа вэ? Энийг тоо баримтаар нэгдүгээрт мэдээлэл авах, ийм асуулт тавья.

Хоёрт нь иргэний хувийн мэдээллээ тухайн иргэн өгөхгүй бол хариуцлага хүлээлгэх үү?

Энэ хоёр асуултад хариулт авъя. Тэгээд нэмэлт.

Г.Занданшатар: Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга ажлын хэсэг хариулна.

Б.Баасандорж: Баасандорж Адьшаа гишүүний асуултад хариулъя.

Саяын таны хөндөж тавьснаас л бол хувь хүнийг одоо хууль бусаар мөрдөж мөшгөх гэдэг. Одоо Эрүүгийн хуулийн зүйлийн байгаа Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлээр зохицуулагдаж өгч байгаа. Хариуцлагын хувьд бол 1-5 хүртэлх жилийн хорих ялыг өгч байгаа.

Ер нь Адьшаа гишүүнээ энэ хуулийн яг нэг гол одоо өмнө нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудаасаа давуу болсон зүйл маань бол тухайн иргэн өөрөө өөрөө өөрийнхөө мэдээлэлд, одоо төр мэдээж хяналт тавина хамгаалах талаас нь. Иргэн маань өөрөө бас давхар хяналтаа тавьдаг. Өөрөө зөвшөөрлөө өгдөг, өөрийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр бусдад түгээдэг мэдээлдэг болж байгаагаараа их гол онцлогтой байгаа.

Өөрөөр хэлбэл одоо тухайн иргэний ямар ч эмнэлэгт болон хувийн мэдээллийг тухайн иргэн зөвшөөрсөн тохиолдолд өгч байгаа.. Тухайн төрийн

байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудад бол аудит орж одоо шалгалт хийж байгаа. Энэ шалгалтаар тухайн иргэнд мэдэгдэх систем байна уу үгүй юу гэдгийг бол нэгд анхаарч байгаа.

Тухайн иргэнд тухайн иргэнтэй холбоотой мэдээллийг мэдэгдэх систем байхгүй бол тухайн байгууллагад нь мөн хариуцлага тооцдог болж байгаа. Тэгэхээр энэ төрийн болон хувийн хэвшлийн бүх төрийн одоо мэдээлэл цуглуулагч. Хариуцагч байгууллагууд маань энэ систем дээр их түлхүү анхаарч байгаа. Энэ тухайн иргэнтэй холбоотой мэдээллийг бусдад түгээхдээ, тухайн иргэн зөвшөөрсөн тохиолдолд иргэнтэй холбоотой эрүүл мэндийн одоо татвартай холбоотой бүртгэлтэй холбоотой бүх мэдээллийг түгээдэг болж байгаагаараа их онцлогтой байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн тодруулж асууя нэг минут.

Ш.Адьяа: Энэ дүрс бичлэг хийж одоо хэчнээн хүнд ямар хариуцлага хүлээсэн тухай баримт өгөх боломж байна уу? Иргэн хувийн мэдээллийг өгөхгүй бол энэ хүнд хариуцлага хүлээлгэх үү гэдэг энэ дээр л хариулт авъя гээд байгаа шүү дээ. Дээр нь ер нь одоо энэ Баасандорж дарга энэ ажлын хэсэг энэ ялангуяа энэ Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой энэ асуудал дээр хариуцлагатай хандмаар байна.

Энэ сайхан ийм халхавчийн юм яриад л цаанаа бол өнөөдөр төр иргэдээ хянах ийм хяналтын системийг бий болгож байгаа. Энэ хяналтын системээрээ дамжуулж тухайн иргэнийг хянадаг, тухайн иргэний мэдээллийг дамжуулдаг. Өнөөдөр энэ асуудал бол хэрээс хэтэрсэн шүү дээ. Өнөөдөр үүрэн телефоны оператор компаниуд хэн дуртай нь мөрдөгч. Цагдаа бичиг өгөөд бүх хүний утасны жагсаалтыг хянадаг, утасны харилцагчийг хянадаг. Энэ асуудал чинь өнөөдөр амь бөхтэй оршиж байгаа шүү дээ.

Прокурорын зөвшөөрөл гэдэг зүгээр тунхгийн шинж чанартай байгаа шүү дээ. Энийгээ яагаад засаж залруулахын оронд энийгээ бүр өнөөдөр хуулиар баталгаажуулах ийм асуудлыг оруулж ирж байна. Энэ дээр одоо ажлын хэсэг ч дахиж нэг тодруулж хариулт авмаар байна.

Г.Занданшатар: Барсүрэнгийн Баасандорж. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэг асуултад хариулна.

П.Сайнзориг: Адьяа гишүүний асуултад хариулъя. Энэ бас техникийн саатлаас сүүлийн хэсгийг сонсож амжлаа. Тэгэхдээ нөгөө мэдээж энэ хуулийн асуудлаар гол асуудал маань ерөнхийдөө 1995 оны хууль.

Хувь хүний нууц гэдэг нь бас тодорхой ерөнхий байсан.

Дээрээс нь хэрхэн яаж хамгаалах процедур нь байгаагүй. Эргээд зөвхөн өөрөө хамгаалагддаг концепц байсан бол бид нар энэ хувь хүний нууцын мэдээллийг авч байгаа, хадгалж байгаа, цуглуулж байгаа энэ байгууллага төр гэлтгүй хувийн хэвшлийг бас үүрэгжүүлж, эргээд энэ иргэнтэй бас одоо юу гэдэг юм тодорхой энэ хувь хүний нууцыг хамгаалах чиглэлд нь бас хариуцлага үүрэгжүүлж өгч байгаагаараа онцлогтой байгаа юм.

Мэдээж энэ мэдээллүүдийг таг бас хязгаарлаад хориглоод нууцлаад байж болохгүй. Үүнийг бас зохистой хэмжээнд эргэлтэд оруулах ёстой.

Тэгэхээр энэ одоо их тэнцвэртэй, маш олон талын эрх ашгуудыг л одоо хамгаалахад энэ хууль байгаа. Мэдээж түрүүний таны асуудаг хууль бусаар мөрдөн мөшгөх, хууль тогтоомж зөрчиж, гүйцэтгэх ажил явуулах асуудлыг бол тусдаа мэдээж хуулиар явуулна. Тодорхой хэмжээний эрүүгийн хариуцлагууд байгаа. Монгол Улсын Засгийн газар ч гэсэн энэ чиглэлдээ ял хариуцлагын бодлогыг чангаруулна гээд Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийг бас намраас өргөн барихаар бас ажиллаж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Ганзоригийн Тэмүүлэн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн төслийг бас үзэж танилцлаа. Тэгэхээр зарчмын хувьд бол яах вэ Хувь хүний мэдээллийг хамгаалах, эрх ашгийг нь хадгалах, хамгаалах ч гэдэг юм уу энэ бол өөрөө Үндсэн хуулиар хамгаалагдсан суурь зарчмын асуудал.

Гэтэл энэ хуулийн төслийг үзээд танилцахаар 2, 3 том зөрчлийн асуудлууд гарч ирж байна. Би яг бүр заалтыг нь онцолж хэлье. 10.1.3, 10.1.4, 13.2 гээд. Энэ заалтууд дээр юу байна вэ гэхээр яг нөгөө хувь хүний эрх ашгийг хамгаалах, хувь хүний эрхийг хадгалах, хамгаалахтай холбоотой заалтыг чинь яг эсрэг 2, 3 томъёолол байгаад байгаа байхгүй юу. Энэ нь юу вэ гэхээр ерөөсөө хүний онц чухал мэдээлэл болсон генетикийн мэдээлэл, удамшлын мэдээллийг ингээд бид нар бол ямар ч бай цуглуулна гэдэг асуудлыг оруулж ирчихсэн байгаад байгаа.

10.1.3 дээр нь 10.4 дээр нь цаашдаа яг юунд ашиглах гэж байгаа юм бэ гээд аваад үзэхээр энэ генетикийн мэдээллийг бол бид нар эрүү, иргэн, захиргааны хэргийг одоо хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд бол ашиглана гээд заачихсан байгаад байгаа юм. 10.1.4 дээр. Тэгэхээр энийг ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм.

Энэ хувь хүний маш онцгой чухал мэдээлэл. Хүний удамшилтай холбоотой хүний нөгөө дахин давташгүй мэдээлэл болсон зүйлийг төр өөрөө нэгд цуглуулна гэдэг чинь өөрөө зарчмын буруу асуудал байна гэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ хүний онцгой энэ чухал одоо удамшлын энэ мэдээллүүдийг генетик нөөцийн мэдээллүүдийг цуглуулчхаад тэрийгээ хэрэг хянан шийдвэрлэхэд ашиглана гэдэг чинь өөрөө би ойлгогдохгүй байх л болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр яаж ашиглах гээд байгаа юм, энийг яаж ашиглаж болдог юм энийг би бол үндсэндээ ерөнхийдөө гаргалгааг нь олуулахгүй байна.

Дээрээс нь энэ 13.2 дээр бас нэг зүйл байгаад байгаа юм. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн эзэн нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулахад ашиглахад зөвшөөрөл шаардахгүй гэж байгаа юм.

Тэгэхээр энэ чинь нөгөө нэг Үндсэн хуулиар хамгаалсан нөгөө нэг хүний эрх ашигтай чинь хүний нөгөө одоо эрэхтэй чинь шууд хамааралтай асуудал болчихоод байгаа юм. Энэ мэдээллийг ер нь нэгдүгээрт 70 жилийн дараа тэрийг ер нь цуглуулж яах гээд байгаа юм. Тэгээд зөвшөөрөлгүй гэж байгаа юм. Тэр цуглуулсан мэдээллийн чинь үр дүнг тэр нас барсан хүндээ биш тухайн тэр хүнийх нь үр сад, ач зээ нарт нь хамаарах гээд байгаа асуудал болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол би зарчмын хувьд энийг бол цуглуулах ямар ч ач холбогдол байхгүй ээ. Төр тэгэхээр хүний ер нь.../минут дуусав/.

Г.Занданшатар: Нямбаатар сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Тэмүүлэн гишүүн энэ шүүх шинжилгээний байгууллага энэ генетик мэдээлэл цуглуулж, түүндээ дүгнэлт хийж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийгдэнэ шүү дээ. Одоо хэн нэг хүн, хэн хүний талаар шүүхэд нэхэмжлэл гаргаад эцэг тогтоох шинжилгээ хийлгэлээ. Энэ тохиолдолд генетик шинжилгээ хийгээд генетикийн мэдээллийг цуглуулаад түүндээ дүгнэлт хийгээд түүнийг нь үндэслэж шүүх шийдвэрээ гаргана л гэсэн үг.

Тэр бид нар тэр 70 жил гэдгийг чинь зүгээр өөрсдөө санаанаасаа зохиож хийгээгүй. Энэ гаднын улс орнуудад яг ийм зохицуулалт байдаг юм байна лээ. Нэн ялангуяа нэр алдартай хүмүүсийн генетик мэдээлэл дээр одоо түшиглэсэн ийм мэдээ мэдээллүүдийг цуглуулдаг ийм зүйлүүд байдаг. Жишээлэхэд, одоо нөгөө алдартай физикч Энштейний тэр генетик мэдээллүүд өнөөдөр бас тодорхой үнэ цэнэ хүрээд түүнийг нь одоо бие биедээ дамжуулж худалддаг ийм зүйлүүд хүртэл байгаа.

Тэгэхээр энэ бол гаднын улс орнуудын энэ Хувь хүний мэдээллийг хамгаалах хууль дээр түшиглэж хийгдсэн зүйл байгаа. Шүүх шинжилгээний байгууллага, гэмт хэрэг, зөрчлийн улмаас шалгагдаж байгаа хүний хурууны хээ буюу биометрик мэдээллийг цуглуулдаг сантай. Энэ сан дээр өнөөдөр 600 гаран гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн мэдээллийн сан байж байх жишээтэй. Энэ маань өөрөө өнөөдрийн явж байгаа түвшинд байгаа харилцааг илүү нарийвчилж хуульчилж өгч байгаа зүйл.

Шүүх шинжилгээний байгууллагын үндсэн хийдэг зүйл бол ерөөсөө гэмт хэргийн тэр ул мөрийг илрүүлж олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй хүний хэргийн газар олдсон эд мөрийн баримт биологийн одоо дээжүүдийг хооронд нь харьцуулж дүгнэлт хийх ийм л чиг үүрэгтэй байгууллага. Тэр шүүх шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашаагаа үргэлжилдэг ийм зүй тогтолтой.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн чинь нэмэлт 1 минут тодруулна.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр би бас энд гайхаад байгаа зүйл маань энэ эрүү дээр иргэн захиргаан дээр бол ойлгохгүй болчихоод байгаа байхгүй юу. Иргэн захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд хүний тэр генетик буюу одоо тэр удамшлын тэр мэдээлэл ямар шаардлагатай юм бэ? Иргэн чинь бол цэвэр ерөөсөө эдийн засаг болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад л очиж байгаа шүү дээ. Тэгэхээр тэрэнд жишээ нь одоо бид нар энийг ашиглах ямар ч шаардлага байхгүй байхгүй юу.

Жишээ нь ер нь бол генетик мэдээллийг өнөөдөр яг өнөөдөр шүүх шинжилгээн дээр юунд ашиглаж байна вэ гэхээр ерөөсөө л эцэг тогтоолгоод л ашиглаж байгаа юм. Эцэг тогтоолгох шинжилгээнд. Бусдаар бол ерөөсөө бид нар энэ мэдээллийг цуглуулах, ер нь ямар ч ач холбогдол байхгүй. Захиргааны хэрэг дээр ч байхгүй, иргэний хэрэг дээр ч тэр хүний генетик мэдээллийг цуглуулж байх шаардлага бол байхгүй.

Дээрээс нь саяын тэр одоо 70 жилийн дараа нас барсан хүний тэр генетик мэдээллийг цуглуулах бас шаардлага ер нь байхгүй шүү дээ. Яг тэрийг цуглуулаад үр дүн нь шинжлэх ухааны ач холбогдолтой ашиглаж байгаа л бол энэ тусдаа асуудал. Гэтэл өнөөдөр энэ чинь хувь хүний мэдээллийг иргэн, эрүү гэмт хэрэг хянан шийдвэрлэх ч гэдэг юм уу энэнтэй холбоотойгоор цуглуулах гэж байгаа бол магадгүй энэ чинь дараа дараагийн үр удамд нь нөлөөлөх хилс хэрэгт хийх.

Г.Занданшатар: Нямбаатар сайд Хишгээгийн Нямбаатар сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Тэмүүлэн гишүүн, энэ иргэний эрх зүйн маргаан гэдэг бол эдийн болон эдийн бус харилцаа гээд та хэлж байна. Нэг том бүлэг нь гэр бүлийн эрх зүйн өөрөө иргэний эрх зүйн том, одоо бүлэг сэдэв болж явдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хийдэг том ажиллагаа бол энэ гэр бүлийн маргаан. Гэрлэлт цуцлалт эцэг тогтоох энэ мэт бүх харилцаан дээр явдаг. Захиргааны эрх зүйн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөн адилхан ийм төрлийн зохицуулалтууд явдаг. Энэ нөгөө юуны гэрчлэлтэй холбоотой маргаан үүссэн бүртгэлийн байгууллагатай холбогдсон маргаан үүссэн энэ тохиолдол болгонд байдаг. Энэ ерөөсөө одоо байгаа амьдрал дээр байгаа харилцааг яаж байгаа юм. Би та бүхэнд одоо шүүх шинжилгээний байгууллагын талаар дараа нь очиж танилцуулга, энэ их өргөн хүрээнд хийгддэг ажлууд. Энэ хүрээндээ л явагдана. Тэрнээс биш одоо төр хувь хүнийхээ мэдээллийг авах гээд цуглуулах гээд шүүх шинжилгээний байгууллага дээр бүх хүний мэдээллийг авах гээд байгаа зүйл.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа асуулт асууна.

Х.Булгантуяа: Энэ хуулийн 6.1.1 дээр иргэн өөрөө хүсэх юм бол ямар ч мэдээллээ хувь хүний нууцын мэдээлэл гэж оруулж болохоор заасан байгаа. Гэтэл яг үнэнийг хэлэхэд төрийн олон үйлчилгээ авахаас гадна хувийн хэвшлийн үйлчилгээг авахад ч гэсэн мэдээллийн эзний зөвшөөрлөөр гэж байгаа юм.

Хэрвээ өөрөө би энэ мэдээллээ би зөвшөөрөхгүй байна. Үхэхэд гээд тэгэхэд бараг л хамаг үйлчилгээг хаачих юм шиг одоогоор тийм зохицуулалтай байгаад байгаа байхгүй юу. Тэгээд үнэнийг хэлэхэд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын хувьд ч гэсэн дээ. Хэрвээ энэ хүн зөвшөөрөл өгөхгүй бол яах юм. Энэ мэдээллийг нь заавал ил тод байгууллага болгохгүй байсан ч гэсэн дээ төрийн үйлчилгээгээр байдаг юм уу, хувийн хэвшил ч гэсэн ээ үйлчилгээгээ хангах бүрэн эрхтэй гэдэг тийм ямар нэгэн зохицуулалт нэгдүгээрт ерөөсөө байхгүй байгаад байна.

Энэ асуудлыг яаж зохицуулсан бэ?

Хоёрдугаарт дэлхий дахинд. Ер нь бас нэг ийм цахим мэдээллийн сан гээд үүсгээд бүх мэдээллийг цахим мэдээллийн сан руу нэлээн эрчимтэй хийж байснаа цахим мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж чадахгүй бол их мэдээлэл бүрдүүлснээс илүү их аюултай юм биш үү гэдэг юм бас өөрийн эрхгүй явж байх шиг байна. Саяхан энэ нөгөө лайн гээд энэ одоо мессенжер шиг ийм системээ Япон хамаг чатуудаа хятадын мэдээллийн нэг компани хандах эрхтэй байсныг нь бид бараг саяхан олж мэдлээ гээд төрийн байгууллагууд нь хүртэл тэрүүгээр мэдээллээ явуулдаг байсан болж таараад энэнд хандахыг жишээлбэл хориглож байх шиг байна. Төрийн ялангуяа байгууллагуудыг. Энэ цахим ер нь баримт бичиг, энэ бүх мэдээллүүдийн аюулгүй байдлыг хангах дээр та бас ер нь дараагийн нэг хэдэн жил төсөв санхүүгийн хувьд ямар ачаалал ирнэ гэж харж байгаа юм бэ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт ер нь яг үнэнийг хэлэхэд ингээд манай төрийн байгууллагуудын асууж байгаа мэдээллүүд ч гэсэн дээ, аягүй хувь хүний хувьд их тийм мэдрэмжгүй мэдээллүүд аягүй их асуух юм.

Жишээлбэл одоо бараг дэлхий дахинд хувь хүний заавал ажилд орох гэж байгаа хүний жендерийг хүртэл заавал асуух албагүй гээд байгаа байхгүй юу. Хүсэхгүй бол жендэрээ заавал бичих албагүй. Зүгээр ажлын байрны шаардлага байх ёстой. Тэгээд тэр ажлын байрны шаардлагад нийцэж байгаа бол тэр эрэгтэй эмэгтэй байх заавал зайлшгүй албагүй гэж байхад манайх жишээлбэл үндэс угсаа.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Нэмэлт 1 минут.

Х.Булгантуяа: Нийгмийн гарал, үндэс угсаа гэх мэтчилэн энэ нэлээн олон мэдээллүүдийг одоо зайлшгүй асуудаг. Ер нь энэ хувь хүний мэдээлэл гэдэг дээр, ялангуяа энэ төрийн байгууллагууд нэг жоохон мэдрэмжтэй байх дээр одоо ер нь цаашид бас яах ёстой юм бэ? Ер нь энэ техник, технологи хөгжөөд хүн бараг нэг 45 секундйнх нь яриаг нь авахад ямар ч текстийг өөрөө ярьж байгаа юм шиг одоо уншуулж болдог тийм одоо тоног төхөөрөмж программууд одоо болсон гэсэн. Тэгэхээр одоо жишээлбэл Булгантуяа миний 45 секундйн яриаг аваад ямар ч текстийг Булгантуяа уншиж байгаа юм шиг яриулж болдог ийм өнөөдөр цаг үед энэ дуу, дүрс ашиглахад хэрвээ эрүүгийн байдаг юм уу, ямар хариуцлагуудыг хүлээлгэх юм бэ? Хүний энэ мэдээллийг авч байгаад одоо хууль бусаар иргэд олон нийтийг одоо буруу ойлголт төрүүлэхээр ийм. Хэрвээ одоо зүйл хэрэг хийх юм бол ямар хариуцлага хүлээхээр орсон байгаа вэ? Энэ хууль дээр.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Дараа нь Нямбаатар сайд нэмж хариулна.

Б.Баасандорж: Хууль зүй, дотоод хэргийн яам Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Нэг дэх асуулт Булгантуяа гишүүн одоо өнөөдөр бол яг хурууны хээний хэрэглээтэй холбоотой асуудлыг асууж байна өнөөгийн. Өнөөгийн нөхцөлд бол хурууны хээний хэрэглээ бол яг түрүүн бас сайдаас хэлж байсан. Яг энэ дээр бол хуулийн хяналтгүйгээр одоо хэрэглэгдэж байгаа. Жишээ нь банкн дээр банк бус санхүү дээр зарим хувийн эмнэлгүүд дээр очиж үзүүлэхээр та хурууны хээгээ уншвал хурууны хээгээ уншуулахгүй бол одоо танд үйлчлэхгүй гэдэг шаардлагыг тавьж байгаа юу гэвэл тавьж байгаа. Яг энэ нь өөрөө өнөөдөр бол Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг бас зөрчиж энэ үйлчилгээг үзүүлж байгаа гэсэн үг.

Тэгэхээр бидний энэний шийдлийг бол ер нь яг энэ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар ер нь энэ хурууны хээг больё. Энэ хурууны хээг зөвхөн сонгогчийн нэрийн жагсаалтыг таньж бүртгэх дээр мөн улсын бүртгэлийн үйлчилгээ авахад л энэ зөвхөн хоёр нөхцөлд хурууны хээг хэрэглэдэг байна. Бусад нөхцөлд энэ цахим гарын үсэг буюу энэ тоон гарын үсгээрээ тухайн иргэнийг сошиал ертөнцөд нь болон одоо биечлэн очиж үзүүлэхэд нь одоо таньдаг байж баталгаажуулдаг байя гэдэг шийдлээр одоо дараагийн хууль дээр хэлэлцүүлэх нь Цахим гарын үсгийн тухай хуулиар хэлэлцүүлэхээр зохицуулж өгч байгаа юм. Мэдээж энэ нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох мөн энэ хяналтын системийг бий болгох өгөгдлийн системийг хийх гэх мэт. Одоо дэд бүтэцтэй холбоотойгоор бол энэ дөрвөн хууль батлагдсантай холбоотойгоор төсөв шаардагдах уу гэвэл шаардагдана. Энэний судалгааг бол одоо 2022 оны төсөв дээр хэрвээ энэ хууль батлагдаад хэрэгжвэл холбогдох тооцоо судалгааг одоо Засгийн газраас өргөн мэдүүлээд 2022 хоёр оны төсвийг танилцуулахад та бүхэндээ танилцуулах болно гэдгийг хэлье.

Мөн тэр эвлүүлэгтэй холбоотой сая бас мөн хөндсөн одоо яг сошиал ертөнцөөр одоо янз бүрийн одоо хүний яриаг эвлүүлдэг зүйлүүд бол байдаг. Энэ дөрвөн хуулийн төслөөр бол яг энэ асуудлыг зохицуулаагүй тэр нь бол санаатайгаар тэр хүнд гэм хорлол учруулах зорилгоор одоо яасан бол?

Одоо Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулиар хүлээлгэх асуудлыг одоо оруулж өгч байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Хассуурийн Ганхуяг асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ хуулийг бол дэмжиж байгаа юм. Тэгэхдээ бас нэг асуудал нь юу вэ гэхээр яг энэ хариуцлагын асуудлыг нэлээн өндөр тавьж явахгүй бол хяналтаа нэлээн өндөр болгохгүй бол одоо ер нь бол ингээд хувь хүнтэй холбоотой энэ бүх мэдээлэл нээлттэй болно. Мэдээж хэрэг зөвшөөрөл авна л гэсэн байгаа. Нийтийн мэдээллийн тухай хуулиар тухайн хүний эзэмшдэг юу байдаг юм одоо байр сууц, лиценз одоо компани ч байдаг юм уу, бүх мэдээлэл бас нээлттэй болно. Хүнийг ер нь бол гүтгэхэд бол 2 сая төгрөгийн Зөрчлийн хуулиар торгуулаад гүтгэж болдог. Улсын Их Хурлын гишүүдийн одоо вайбер групп дээр бичээстэй байсан зарим зүйлийг сошиал шар сонингуудаар тавигдаад явчихдаг. Тэгээд энэ мэдээллийг нь цаашаа ашиглах, гүтгэх энэ асуудлууд дээр одоо угаасаа манай Эрүүгийн хууль дээр зүйл заалт нь байгаа боловч энэ асуудал угаасаа нээлттэй хэвээрээ л байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо энэ шинэ хуулиудыг ашиглаад ерөөсөө л тэр хүний талаар бүх мэдээллийг ашиглах боломжтой болно гэсэн үг. Тэр тусмаа нөлөө бүхий этгээд ямар ч хүнийг одоо бүх мэдээллийг нь аваад яаж л бол яаж болно л гэсэн үг. Тэгэхээр энэ Зөрчлийн хуулиар энэ юугаар явах юм уу? Ер нь энэ хяналттай холбоотой хариуцлагатай холбоотой зүйл заалтыг маш тодорхой оруулж өгөхгүй бол ямар сайндаа бид нар тэр нэг авто замын тэр торгуулиа төлж чадахгүй байгаа, төлөхгүй байгаа хүмүүс дээрээ бид нар олж чадахгүй нөгөө улсууд нь торгуулиа төлөхгүй л байж байна шүү дээ. Тэгээд л одоо тэрийг нь өршөөх гэж байна.

Тэгэхээр ингээд энэ хувь хүний мэдээллийг чинь аваад л, одоо тэр фэйсбүүк дээр тэр тролл гэдэг билүү юу ч гэдэг билээ тэд нараар дамжуулаад л гүтгэлэг бичээд л тавьчихдаг шүү дээ. Тэгээд энэ асуудлуудыг ер нь цаашид яаж зохицуулах вэ? Яаж хяналт тавих вэ? Бид нарт ер нь яг ийм хяналт тавих дэд бүтэц нь байна уу, үгүй юу гэдэг асуулт л асуух гэсэн юм даа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Барсүрэнгийн Баасандорж дарга.

Б.Баасандорж: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яам Баасандорж өнөөдөр бол ингээд яг энэ хуулийн төслийг боловсруулахад бид нар судалж үзэхэд яг ямар мэдээлэл алдагдвал ямар хариуцлага тооцох юм. Ер нь тухайн хувь хүнтэй холбоотой хуулийн этгээдтэй холбоотой ямар мэдээлэл нь нээлттэй байх юм, ямар мэдээлэл нь хязгаартай байх юм, ямар мэдээлэл нь хаалттай байх юм гэдэг нь тодорхой байхгүй байсан. Мөн хариуцлагын систем ч гэсэн яг тодорхой биш. Өөрөөр хэлбэл нөгөө нээлттэй, хаалттай мэдээлэл гэж тодорхой ангилж өгөөгүйгээс зүгээр хүний хувь хүний нууцлал гэдэг нэг ерөнхий нэртэй 1995 оны хуулиар зохицуулдаг. Хувь хүний нууцад ерөөсөө дөрвөн үндсэн мэдээлэл хуульд заасан бусад гээд нэг ерөнхий хийгээд өгчихсөн.

Тэгээд ямар хариуцлага тооцох вэ гэдэг нь мөн Хувь хүний ний нууцын мэдээллийн тухай хууль дээр байдаггүй байсан. Тэгэхээр бид нар сая Ганхуяг

гишүүн бас чухал асуулт асууж байна л даа. Түрүүн Булгантуяа гишүүн ч гэсэн. Яг бид нар энэнтэй холбоотой энэ аюулгүй байдалтай холбоотой Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж байгаа. Эрүүгийн хуулийн 26 дугаар зүйл бүлэгт буюу 26.1 дээр одоо цахим төхөөрөмж, кибр орчинд зөвшөөрөлгүйгээр халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, завсарласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж сүлжээг ашиглах боломжгүй болгосон бол гэх мэт одоо бид нар тэр тухайн үйлдэл бүр дээр нь хариуцлагуудыг нь тодорхой хийж өгсөн байгаа. Ингэсэн тохиолдолд бол 1-5 жил хүртэл хугацаагаар зорчихыг хязгаарлах, эсвэл 1-5 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэе гэдэг зүйлийг бол Кибрийн аюулгүй байдлын тухай хуулийг дагалдуулаад Эрүүгийн хууль дээр бид өөрчлөлтийг оруулж өгсөн байгаа юм.

Г.Занданшатар: Болсон уу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Дэмжсэн нь дэмжээгүй. Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Цахимаар байна уу? Нэг гишүүн байна.

Эрхэм гишүүн Ганзоригийн Тэмүүлэн үг хэлнэ.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ Хувь хүний мэдээллийн тухай, мэдээллийг хамгаалах тухай хуулийн төсөл дээр би бас түрүүн хэлсэн. Энэ дэмжихгүй 2, 3 заалтууд бол байна. 10.1.3, 10.1.4 болон энэ 13.2 дахь заалтууд гээд. Ерөөсөө хувь хүний генетикийн мэдээлэл буюу хүн хувь хүний одоо удамшилтай холбоотой, эрүүл мэндтэй холбоотой энэ удмын сангийн холбоотой энэ мэдээллүүдийг бол тэр болгон бол цуглуулдаггүй юм. Гэтэл энэ хуулийн төсөл дээр төр энийг бол цуглуулна. Төр дээрээс нь энийг боловсруулна. Төр өөрөө энийг бас цаашид ашиглана гэдэг зүйл заалтаар орж ирээд байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө ерөөсөө болохгүй 2, 3 энэ зүйл заалтууд бол энд байна. Яагаад вэ гэвэл энэ өөрөө онцгой чухал мэдээлэл. Тухайн тэр одоо юу гэдэг юм улс үндэстний ч тэр, хүний удмын сангийн аюулгүй байдалтай ч холбоотой чухал асуудал талаас аваад үзсэн бид нар тэр болгон хүний тэр генетикийн мэдээллийг бол төр цуглуулж байх ёсгүй. Зөвхөн магадгүй тэр гэмт хэргийг илрүүлэхэд, дээрээс нь эцэг тогтоолгох гэдэг энэ онцгой хоёр нөхцөлд ашиглана уу гэхээс биш бусад тэр одоо иргэний хэргийг шийдэхэд, захиргааны хэргийг шийдэхэд ч гэдэг юм уу хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд генетик мэдээллийг бол ашиглах эрх зүйн үндэслэл бол байхгүй.

Дээрээс нь 13.2 дээр түрүүн заачихсан байсан тухайн хүнийг нас барсны дараа 70 жилийн дараа ч гэсэн тухайн тэр мэдээллийг бол зөвшөөрөл шаардахгүйгээр төр ашиглана гэдэг асуудлыг тавиад байгаа байхгүй юу.

Мэдээллийг цуглуулна, боловсруулна, ашиглана гэж байгаа юм. Тэгэхээр энэ чинь одоо бид нар ядаж хүн нас барсных нь дараа ч гэсэн хүн ёсоор нь бид нар хандах ёстой байгаа. Олон улсад энэ жишиг бол байхгүй ээ. Хувь хүний генетик нөөцийн мэдээллийг цуглуулдаг, хадгалдаг, ашигладаг тийм жишиг бол байхгүй. Магадгүй манай урд хөршид л байж магадгүй. Бусдаар бол өөр улсад бол тэрийг зөвшөөрдөг, ашигладаг, хадгалдаг ийм одоо зарчим бол байхгүй шүү. Магадгүй түрүүний ярьж байсан тэр анште гэж байгаа. Анштегийн мэдээллийг цуглуулахад хүртэл үр хүүхдүүдээс нь зөвшөөрлийг нь авч байгаад, төрөл саднаас нь зөвшөөрлийг нь авч байгаад тэрийг магадгүй судалж байгаа.

Гэтэл зөвшөөрөл шаардахгүйгээр ашиглана гэдэг чинь бол Үндсэн хуулийг зөрчиж байгаа асуудал болчихоод байгаа юм. Хувь хүний мэдээлэлтэй холбоотой хувь хүний эрх ашгийг зөрчиж байгаа холбоотой асуудал ч байгаа учраас энийг

бол бид нар хэлэлцүүлгийн явцад анхаараад засаж залруулаад зөвхөн онцгой нөхцөлд гэмт хэрэг илрүүлэхэд тухайн магадгүй тэр эцгийг эцэг тогтооход ашиглана гэдэг байдлаар оруулахгүй бол нийтээрээ төр бол хувь хүний энэ нууц мэдээллийг онцгой энэ чухал мэдээллийг генетик мэдээллийг бол, цуглуулж, хадгалж, хамгаалж, ашиглаж бол болохгүй гэдэг бол байр суурьтай байгаад байгаа юм.

Г.Занданшатар: Цахимаар эрхэм гишүүн Жигжидийн Батжаргал үг хэлнэ ээ.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өнөөдрийн амар амгаланг айлтгая. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Хэлэлцэхийг нь дэмжиж байгаа. Угаасаа бид ямар ч тохиолдолд энэ мэдээллийн дата бааз бүрдүүлэх үйл ажиллагаа явагдана. Нэгэнтээ л биднүүс цахим засаглалын тухай ярьж, дижитал шилжилт хийх тухай л ярьж байгаа бол энэ мэдээж хийгдэж таарна, ойлгомжтой.

Тийм учраас харилцаагаа хуулиар зөв зохицуулж, зөв үйл ажиллагаа явуулах тухай асуудал байгаад байгаа юм. Тийм учраас би энэ хуулийн төслийг дэмжиж байна гэж. Төр өөртөө байгаа мэдээллийг чухам ямархуу байдлаар ашиглах ёстой юм. Ашигласан тохиолдолд түүнийг тэр тухайн яг ашиглаж байгаа зүйлдээ л ашиглахаас биш бусдад ил гаргадаг, барьдаг юмнуудыг нь бүгдийг нь хязгаарлаж зогсоох ёстой. Энүүнийг бол энэ хуульд бүр нарийсгаж тусгаж өгөх, оруулах ёстой. Шүүх дээр ирдэг юм уу, энэ гүйцэтгэх ажлын шугамаар асуудалд ханддаг байгууллагууд зөвхөн тэр үйл ажиллагаандаа шалгаад, тэр материал дотор нь үлдээдэг хэлбэрээрээ байх юм уу, ямар хэлбэрээр юм байх юм. Тэрнээс цахим руу гаргаад тавьчихдаг гэдэг юм уу, олон нийтийн сүлжээ рүү гаргаад тавьчихдаг юм байж таарахгүй. Энүүнийг бол онцгой анхаарал хандуулж, хязгаарлалтыг нь хийж өгөх ёстой гэж. Хувийн байгууллагууд иргэдээс мэдээлэл цуглуулж болно. Өөрөө зөвшөөрөх юм бол өгнө гээд ийм юм яриад байх юм. Угаасаа үйлчилгээ авах гээд л гэдэг юм уу, очиж байгаа улсууд чинь цаад улсуудын хүссэн мэдээллийг л одоо гаргаж өгөх түвшинд л очно шүү дээ.

Тэгэхээр ямар мэдээлэл авч, цуглуулж болох юм гэдгийг нь, энэ хуулиар хязгаар заагийг нь тогтоож өгөхгүй бол наадах чинь болохгүй ээ. Тийм учраас тэр хувийн байгууллагуудын хүний мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны хязгаар заагийг маш нарийн тогтоож өгөх ёстой, буцаагаад түүнийг ямархуу байдлаар хамгаалж ашиглах ёстой гэдэг юмаа юмыг нэг их тодорхой болгож өгөх ёстой гэж би ингэж ойлгоод байна. Ингэхгүйгээр энэ бас зогсож болохгүй нь гэж.

Дараагийн нэг зүйл энэ банкныхан гэдэг юм уу, бүртгэлийнхэн хүний мэдээллээ янз бүрийн санаатай, санаандгүй байдлаар их задруулдаг улсууд. Энэ нөхдүүдэд ямархуу байдлаар тэр нууцлалын зэрэглэл хадгалах байдал хэрэв тэгж чадаагүй ам султай байсан бол ямар хариуцлага үүргийг нь энэ хуульд бүр их тодорхой зааж өгөх ёстой шүү. Ингэхгүй бол энэ болохгүй нь гэдгийг зориуд бас нэг хэлчихмээр санагдаад байна.

За ер нь явж явж мэдээллийнхээ бааз суурийг нэлээн задгайдуу байлгаад, тэгээд нийтийн сүлжээ янз бүрийн юманд гаргаад, янз бүрийн байдлаар ашиглаад байх юм бол түншлэлийн харилцаанд нэлээн том асуудал үүсэж, тэр хэмжээгээр тийм далд хэлбэрийнхээ юм руу явцгаачихна шүү. Энэ хууль өөрөө нэлээн зөв зохицуулалттай гарах ёстой гэж ингэж ойлгож байна.

Дараагийн төгсгөлд нь хэлмээр байгаа зүйл. Ерөөсөө энэ программ дата мэдээллийн сан сүлжээнийхээ. Асуудлын өөрийнх нь аюулгүй байдлыг хангах асуудлыг.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

55 дагалдах хуультай хууль байна шүү.

Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 36 гишүүн дэмжиж 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул Төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ хуулийн санкцуудыг сайн хийж өгч сайн анхаармаар юмнууд байна шүү. Хүний эрхийн Үндэсний Комисс яаж хяналт тавих юм. Энэ олон 55 хууль чинь бүгд л их сайн уялдмаар юм байна.

Дараагийн асуудалд орно.